



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/83


Хэрлэн сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 30 дугаар зүйлийн 30.1, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн сумын 5 дугаар баг, Мал эмнэлгийн зүүн талд байрлах 150671 м<sup>2</sup> газрыг, цэвэрлэх байгууламжийн зориулалтаар "Хэнтий-Ус" ХХК-д 47 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.
2. "Хэнтий-Ус" ХХК-ий эзэмшиж буй газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.
3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.
4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг "Хэнтий-Ус" ХХК /Г.Батгэрэл/-д үүрэг болгосугай.
5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 93 дугаар захирамжийн хавсралтын 11 дэх хэсэг, Хэрлэн сумын Засаг даргын 2015 оны А/170 дугаар захирамжийг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА